# "БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Багануур дүүрэг

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Биелэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|
| | **НЭГ. ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛЭХ** | | |
| 1 | Албан хаагчдыг 7 хоногт 1 удаа спорт заалаар хангах | ➢ Байгууллагын албан хаагч нарыг түрээслүүлэгч компани Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хамт олонтой цуг долоо хоног бүрийн 5 дахь өдөр зааланд тоглуулж, дасгал хөдөлгөөн тогтмол хийлгэж байна.<br>➢ Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд хөл хорио тогтоосон хугацаанд спорт заалаар хичээллэх арга хэмжээг зогсоосон. | 100% |
| 2 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийлгэх | ➢ Эрүүл мэндийн даатгалаар 5 албан хаагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.<br>➢ Байгууллагын ажилчид өдөр бүр 11:00 цагт ажлын байрны дасгал хөдөлгөөн тогтмол хийж хэвшсэн.<br>➢ Мөн хөл хорионы үеэр хөдөлгөөний дутагдалд орохоос сэргийлэх талаар албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.<br>➢ Дэлхий даяар тархсан корона вирусын шинжилгээнд байгууллагын албан хаагчид хамрагдсан. | 100% |
| 3 | Албан хаагчдын бие бялдрын сорил, чийрэгжилтийн түвшинг үнэлж өмнөх жилийн мөн үетэй харьцуулан танилцуулах | 2020 оны 04 дүгээр сард нийт албан хаагчдаас бие бялдрын сорил авч чийрэгжилтийн түвшинг үнэлэхэд хөдөлгөөний дутагдалтай албан хаагч байхгүй А үнэлгээтэй гарсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,4%-аар өссөн. | 100% |
| 4 | Албан хаагч нарт ажиллах тав тухтай орчныг бүрдүүлж өгөх | ➢ Тасалгааны агааржуулалт хэвийн бөгөөд ариун цэврийн өрөөний стандарт шаардлагыг хангаж тохижуулав.<br>➢ Ажлын байранд цэвэрлэгээг тогтмол хийж байгаа ба цар тахалтай холбоотойгоор ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 7 хоногт 1 удаа зохион байгуулж байна. | 100% |
| | **ХОЁР. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИНГ НЭМЭГДҮҮЛЭХ** | | |
| 5 | Албан хаагчдад хоол унааны мөнгө олгох | Албан хаагч нарт сар бүр хоол, унааны мөнгө олгосон. | 100% |
| 6 | Албан хаагчдын ажлын гүйцэтгэл болон хөдөлмөрийн гэрээг дүгнэж хамт олны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, урамшуулах<br>• Сар – ур чадварын нэмэгдэл олгох<br>• Улирал - ур дүнгийн нэмэгдэл олгох | Албан хаагч нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэн ур чадварын нэмэгдэл олгосон. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Албан хаагч нарын ажлын гүйцэтгэл, үр дүн, ажилласан хугацаанд үндэслэн төрийн одон медаль, салбарын болон нийслэлийн шагналуудад тодорхойлох | 2020 оны 2 дугаар сард Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн конструктор инженер Д.Алтангэрэлийг төрийн дээд Алтан гадас одонгоор шагнуулахаар тодорхойлж, 2020.08 дугаар сард шагнагдсан. | 100% |
| 8 | Байгууллагын 2020 оны шилдэг ажилтанг ажлын гүйцэтгэл болон хамт олны саналаар шалгаруулж, урамшуулах | Нийт ажилтан албан хаагчдын ажлын үр дүнд үндэслэн хамт олны саналаар 2020 оны шилдэг ажилтанд Б.Мөнгөнхуягийг тодорхойлов. | 100% |
| | **ГУРАВ. АЛБАН ХААГЧДАД ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ** | | |
| 9 | Албан хаагч шинэ орон сууцтай болох, хурим хийх тохиолдолд байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх | Тайлант онд шинэ орон сууцтай болсон, хурим хийсэн албан хаагч байхгүй. | - |
| 10 | Шинэ хүүхэдтэй болох, хүүхэд үрчилж авах тохиолдолд байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх | Тайлант онд шинэ хүүхэдтэй болсон, хүүхэд үрчилж авсан албан хаагч байхгүй. | - |
| 11 | Олон улсын хүүхдийн баяр болон Шинэ жилийн үйл ажиллагаа зохион байгуулж албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч, холбогдох зардлын 50%-ийг байгууллага хариуцах | ➢ Олон улсын хүүхдийн баяр буюу Монгол улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг болон баярын тортыг гардуулан өгсөн.<br>➢ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд 5 хүртэлх тооны танин мэдэхүйн бэлэг бэлдэж, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст хүлээлгэн өгсөн. | 100% |
| 12 | Албан хаагч нарт 0-15 насны хүүхдийн төрсөн өдөөр нь ажлын ачааллыг харгалзан үзэж хагас болон бүтэн өдрийн цалинтай чөлөө олгох | Тайлант онд 5 ажилтанд ажлын ачааллыг харгалзан үзэж хагас өдрийн цалинтай чөлөө олгосон. | 100% |
| 13 | Албан хаагчдын ар гэрт гачигдал гарсан тохиолдолд цалинтай чөлөө олгож, тусламж үзүүлэх | Байгууллагын Жолооч Н.Жаргалсайханы ар гэрийн гачигдалд байгууллагын ажилчид сэтгэлийн хандив тусламж үзүүлсэн. | 100% |
| | **ДӨРӨВ. АЛБАН ХААГЧДЫН МЭРГЭЖЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ** | | |
| 14 | Албан хаагч дотоодын их, дээд сургуулийн Магистрын зэрэг горилсон бүтээл хамгаалах сард 5 хоногийн, докторын зэрэгт 10 хоногийн цалинтай чөлөө олгох | Тайлант онд дотоодын их, дээд сургуулийн Магистр, докторын зэрэг горилсон бүтээл хамгаалах албан хаагч байхгүй байна. | - |
| 15 | Мэргэшсэн инженерийн багц сургалтад хамрагдаж буй инженерүүдэд цалинтай чөлөө олгож, сургалтад хамруулах | Үйлдвэрлэл, технологийн албаны инженер Б.Мөнгөнхуяг нь байгууллагын зардлаар мэргэшсэн инженерийн багц 5 хоногийн сургалтад хамрагдсан. | 100% |
| 16 | Мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх 3 сар хүртэл хугацааны сургалтад хамрагдаж буй албан хаагчдад чөлөө олгож ажлын байрыг хэвээр хадгалах | Тайлант онд 3 сар хүртэлх хугацааны сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй. | - |
| 17 | Гадаад улс руу хэлний бэлтгэл, мэргэжлийн сургалтад 6 сар хүртэл хугацаанд суралцах албан хаагчдад чөлөө олгож, ажлын байрыг хэвээр хадгалах /1 албан хаагч 2 жилд 1 удаа/ | Тайлант онд гадаад улс руу суралцахаар явсан албан хаагч байхгүй. | - |
| 18 | Гадаад улсад магистр болон докторын зэрэг хамгаалах албан хаагчдад суралцах мэргэжлийн чиглэлээс | Тайлант онд гадаад улс руу магистр болон докторын зэрэг хамгаалахаар явах хүсэлт гаргасан албан хаагч байхгүй. | - |

| | | | |
|---|---|---|---|
| | хамааран 1,5-3 жилийн хугацаанд чөлөө олгож, ажлын байрыг хэвээр хадгалах | | |
| 19 | Гадаад болон дотоодын Манлайллын сургалтын сонгон шалгаруулалтад тэнцсэн албан хаагчдад чөлөө олгох | Одоогийн байдлаар шалгаруулалтад оролцсон албан хаагч байхгүй байна. | - |
| | ТАВ. ХАМТ ОЛОНЧ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ | | |
| 20 | Хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор дотооддоо уралдаан, тэмцээн зохион байгуулах | ➢ Эхний хагас жилд Дэлхий даяар тархсан корона вирусын цар тахалтай холбогдон гарсан ЗГ-ын 30 дугаар тогтоол, УОК-ын 80 дугаар албан бичиг, НЗД-ын А/436 дугаар захирамжийн дагуу нэлттэй өдөрлөг, уулзалт, уралдаан, тэмцээн зохион байгуулаагүй.<br>➢ "Дэлхийн алхалтын өдөр"-ийг улс орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан байгууллагын ажилтан албан хаагч нарын дунд "Хэн хамгийн олон алхам алхах вэ?" бичил уралдааныг хамт олны дунд зохион байгуулсан ба уралдааны ялагчаар Э.Энхзаяа шалгарсан. | 100% |
| 21 | Нийслэл болон дүүргээс зохион байгуулах өдөрлөг, арга хэмжээ, тэмцээн уралдаанд идэвхтэй оролцох | Байгууллагын албан хаагчид дараах сургалтуудад хамрагдсан. Үүнд:<br>**1. Нийслэлээс зохион байгуулсан сургалт, хурал, уулзалт:**<br>2020.01.08 - НББ-ийн сургалт,<br>2020.01.16 - Балансын сургалт<br>2020.03.24 - ННЗБ-уудын удирдах ажилтнуудын дунд зохион байгуулсан эхний цахим хуралд байгууллагын удирдлага оролцсон.<br>2020.05.11 - Төрийн албан хэрэг хөтлөлтийн сургалтад цахимаар,<br>2020.08.07 - ҮДГ болон ГТ боловсруулах сургалт<br>2020.08.10 - Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааны явцын мэдээлэлтэй танилцах, цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх уулзалт хэлэлцүүлэг<br>2020.08.19 - Төслийн удирдлагын сургалтын модуль боловсруулах хэлэлцүүлэг<br>2020.09.23 – МҮИС-ийн танилцуулга, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт үнэгүй хамрагдах арга хэмжээ<br>2020.09.28 – УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ Багануур дүүргийн удирдлагуудтай хийсэн уулзалт<br>2020.10.08 – УУХҮЯ дээр зохион байгуулсан Аж үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээний журам боловсруулах хэлэлцүүлэг<br>2020.10.29 – Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойн арга хэмжээ<br>2020.12.15,16 Германы GIZ хөтөлбөрөөс зохион байгуулсан "Германы бизнесүүдтэй хэрхэн харилцах вэ" сургалт<br><br>**2. Дүүргээс зохион байгуулсан сургалт, хурал, уулзалт:**<br>2020.01.23 - "Тэмбүүг устгая" | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2020.01.27 - Томуу, томуу тест өвчний тархалт болон шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт<br>2020.07.24 - Тоон гарын үсэг хэрэглэх тухай сургалт<br>2020.08.31 – “Гэр бүлийн эрүүл харилцаа” сургалт<br>2020.09.18 – Хүний нөөцийн системтэй холбогдох сургалт<br>2020.09.23 – ХХҮХ-ийн цахим систем ашиглах сургалт<br>2020.09.25 – “Залуучуудаа сонсох өдөр” нээлттэй өдөрлөгт байгууллагын ГБХЗЗ оролцож АХА тэмцээнд түрүүлсэн.<br>2020.10.08 – “Мэдээлэл технологийн хүний нөөцийн хөгжил” сургалт<br>2020.10.23 - Европын сэргээн босголт хөгжлийн банкны Жижиг дунд бизнесийн санхүүжилт, хөгжлийн групп дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан уулзалт<br>2020.10.29 – Багануур дүүргийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын нэгдсэн арга хэмжээ<br>2020.10.30 - Багануур дүүргийн ЭМТ-ийн ковид-19, сүрьеэ, ТТӨ, ХБӨ-ийн талаарх сургалт<br>2020.11.09 – Багануур дахь Монголын Залуу инженерүүдийн анхдугаар чуулга уулзалт<br><br>**Багануур дүүргийн Захирагчийн ажлын албанаас 2020 онд** зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээнд хамт олноороо идэвхтэй оролцож хуваарилсан газрыг цэвэрлэж, тайланг хүргүүлэн ажилласан. Үүнд:<br>- 2020.02.15-ны өдөр “Хоггүй шинэлцгээе” аяны хүрээнд Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ<br>- 2020.04.04-ний өдөр Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ<br>- 2020.05.02-ны өдөр “Их цэвэрлэгээ – 90 минут” бүх нийтийн их цэвэрлэгээ<br>- 2020.05.23-ны өдөр “Ногоон бүс”-ийн цэвэрлэгээ<br>- 2020.07.10-ны өдөр Үндэсний их баяр наадмыг угтсан цэвэрлэгээ<br>- 2020.08.07-ны өдөр “Шарилжгүй Улаанбаатар-5” аяны шарилж устгал<br>- 2020.08.15-ны өдөр Хичээлийн шинэ жилийг угтсан цэвэрлэгээ<br>- 2020.10.09-ний өдөр “Бүх нийтээрээ цэвэрлэгээнд нэгдье” ногоон бүсийн цэвэрлэгээ<br>- 2020.11.20-ны өдөр Цас цэвэрлэгээ<br>- 2020.12.18-ны өдөр Шинэ жилийг угтсан цэвэрлэгээ<br><br>➢ Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийн бөөгнөрөлийг үүсгэхийг хориглосон тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэн албан хаагчид гэр хороолол | |

| | | | |
|---|---|---|---|
| | | амьдардаг байгууллагын 3 ажилтны гэрийн хашаанд мод тарьж арчилгаа услалгааг хийсэн.<br>➢ Дүүргийн Засаг даргын А/190 дүгээр захирамжийн хүрээнд зохион байгуулагдсан "Мод тарих өдөр"-ийн үйл ажиллагаанд албан хаагчид биечлэн оролцож чадаагүй тул Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтын дагуу хандивын мөнгө цуглуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд тушааж баримтыг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 93 дугаартай албан бичгээр мөн албан бичигт заагдсан цахим шуудангийн хаягаар тус тус хүргүүлэв.<br>➢ "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн арга хэмжээний хүрээнд тогтоосон газарт 2020.10.12-ны өдөр цэнэг услалгааг хийв.<br>➢ Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны удирдамжийн дагуу холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан тайланг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтний цахим хаягаар 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр илгээсэн.<br>➢ Багануур дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/326 дугаар захирамжийн дагуу “Сүрьеэгүй хамт олон” үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан биелэлтийг 11 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн.<br>➢ УОК-ын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр албан даалгавар, НОК-ын 10 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлээр үүрэг болгосон “Маскаа зүүе, гараа угаая” 2 дугаар аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг 7 хоног бүрийн Лхагва гарагт албан бичгээр дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэст, 7 хоног бүрийн Пүрэв гарагт ubhealth2020@gmail.com цахим хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна. | |
| 22 | Ажлын дадлага туршлага олгох зорилгоор салбарын томоохон байгууллага, үйлдвэрүүдтэй танилцах аяллыг зохион байгуулах | Ковид-19 цар тахлын улмаас аяллыг хойшлуулаад байна. | - |
| 23 | Нийтээр амрах баярын өдрүүдэд байгууллага эсвэл дүүргийн хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэсэн албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.3 дахь заалтыг үндэслэн нөхөн амруулах | - Шинэ төрлийн корона вирустэй холбогдон гарсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс НЗД-ын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/191 дүгээр захирамж, НЗДТГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн үүрэг чиглэл хүргүүлэх тухай 03/846 дугаар албан бичгийн хүрээнд 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс 6 дугаар сарын 5-ны өдөр хүртэлх хугацаанд Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч ажилласан эргүүлийн тайланг нэгтгэн Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2020 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 105 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | - НЗДТГ-ын 2020.11.12-ны өдрийн А/1242 дугаар захирамжийн дагуу Газрын даргын мөн өдрийн А/33 дугаартай тушаалаар хязгаарлалт тогтоосон хугацаанд ажиллах албан хаагчдын хуваарийг баталж мөрдөн ажилласан. | |
| | Байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд: | - Томуу, томуу төст өвчлөлт болон шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, ажилчдын дархлааг сайжруулах зорилгоор 02, 11 дүгээр саруудад халуун аарц аян өрнүүлж ажилласан.<br>- 2020 оны 03 дугаар сард Байгууллагын ажилчид өөрсдийн цалингаас Өндөржүүлсэн бэлэн байдлын үед 24 цагийн турш ээлжээр ажиллаж байгаа дүүргийн Онцгой комисст 450,000 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 150,000 мян.төг тус тус хандивласан.<br>- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн А/342 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган байгууллагын албан хаагч нарт 920,0 мянган төгрөгний урамшуулал олгосон.<br>- <u>Албан хаагчдыг Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд:</u> нэг удаагийн бээлий, N95 амны хаалт, Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн давхар шүүлтүүрт амны хаалт, /санитол/ гар халдваргүйжүүлэх бодисоор ханган, байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээний материал, ариутгалын бодис зэргийг хангалттай нөөцлөн ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% |
| | | **Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн арга хэмжээ** | **1** |
| | | **Хэрэгжилтэд тооцох боломжгүй ажлын тоо** | **7** |
| | | **Дундаж хувь** | **100%** |

ХЯНАСАН:
НЯГТЛАН БОДОГЧ Л.ОЮУНЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА